

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2023 оны 03 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
	<p>Үүрэг даалгавар НЭГ: Улс, нийслэлийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ худалдан авах ажиллагааг эрчимжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах. /Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Замын хөгжлийн газар, Хөрөнгө оруулалтын газар, Дүүргийн Засаг дарга нар, бусад байгууллагууд/</p>			
1	<p>Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Шинээр хэрэгжүүлэх 24 төсөл арга хэмжээ тендерийн шалгаруулалтын шатанд ➢ 2022-2023 он дамжин хэрэгжих 11 төсөл арга хэмжээ байна. <ul style="list-style-type: none"> • Бүрэн дууссан хүлээлгэн өгсөн 9 төсөл арга хэмжээ • Гэрээ байгуулсан 1 арга хэмжээ • Тендерийн шатандаа 1 төсөл арга хэмжээ тус тус хэрэгжиж байна. <p>Дүүрэгт Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар</p> <ul style="list-style-type: none"> ➢ 2022-2023 он дамжин хэрэгжиж буй 43 төсөл арга хэмжээ /146,923.1 сая төгрөг/ <p>Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр хэрэгжих</p> <ul style="list-style-type: none"> ➢ 1 төсөл арга хэмжээ /300.0 сая төгрөг/ ➢ 2022-2023 он дамжин хэрэгжих 10 төсөл арга хэмжээ /39,632.98 сая төгрөг/ ➢ 1 төсөл арга хэмжээ /1,200.0 сая төгрөг/ ➢ 2022-2023 он дамжих хэрэгжих 4 төсөл арга хэмжээ /865 сая төгрөг/ <p>Улс, нийслэл, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтын нийт 59 төсөл арга хэмжээ хэрэгжиж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Бэлтгэл ажил хийгдэж байгаа 9 төсөл арга хэмжээ: ➢ Тендерийн шатандаа байгаа 10 төсөл арга хэмжээ: ➢ Гэрээ байгуулах шатандаа байгаа 1 арга хэмжээ: ➢ Гэрээ байгуулагдан ажил хийгдэж байгаа 20 төсөл арга хэмжээ: ➢ Гүйцэтгэл 100% дууссан 19 төсөл арга хэмжээ тус тус байна. <p>Нийслэлийн Замын хөгжлийн газар, Хөрөнгө оруулалтын газар, Барилгын хөгжлийн төвд дүүргийн нутаг дэвсгэрт Улс, Нийслэл, Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт тавин хамтран ажиллах тухай албан бичгийг 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдөр хүргүүлэн ажилласан.</p>			70

	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр дүүргийн 7-24 дүгээр хороодын 13 байршилд гудамж сайжруулах ажлуудын зураг төсвийг “Түвшин тумбааш”, “Би жи рояал” ХХК-иуд гүйцэтгэн дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлэн тендер зарлагдсан.			
Үүрэг даалгавар ХОЁР: Хөрөнгө оруулалтын хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох хууль, журамд нийцүүлэн ил тод, шуурхай зохион байгуулан, ажлын уялдаа холбоог сайжруулж, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн бүх үе шатанд тавих хяналтыг эрчимжүүлж ажиллах. /Бүх шатны нутгийн захиргааны байгууллагууд/				
2	<p>Дүүргийн төсвийн хөрөнгөөр:</p> <ul style="list-style-type: none"> ➢ 2023 онд шинээр хэрэгжүүлэх 23 төсөл арга хэмжээ; ➢ 2022-2023 он дамжих хэрэгжих 48 төсөл арга хэмжээнээс тендерийн шатандаа 8 төсөл арга хэмжээ; ➢ Гэрээ байгуулж ажлыг эхлүүлсэн 16 төсөл арга хэмжээ; ➢ Бэлтгэл ажил хангагдан, худалдан авах ажиллагааны тендэр зарлагдахаар хүлээгдэж буй 21 төсөл арга хэмжээ; ➢ Ажлыг бүрэн гүйцэтгэн хүлээлгэн өгсөн 26 төсөл арга хэмжээ байна. <p>Бүрэн дуусаж, хүлээлгэн өгсөн төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо Төсвийн тухай хууль болон Монгол улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолыг мөрдлөг болгон ажиллаж байна.</p>			70
Үүрэг даалгавар ГУРАВ: ЗАСГИЙН ГАЗРААС 2023-2024 ОНЫГ "АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ЖИЛ" БОЛГОН ЗАРЛАЖ, АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ "5-ш" АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД: Төрийн албаны тухай хуульд заасан төрийн жинхэнэ албан хаагчид тавигдах нийтлэг болон тусгай шаардлагыг хангаагүй, албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжил, мэргэшил, ур чадварын шаардлагыг хангаагүй, дүйцүүлэн тооцох журам зөрчин томилогдсон албан хаагчийг чөлөөлж, хуульд нийцүүлж ажиллах. /Бүх шатны нутгийн захиргааны байгууллагууд/				
3	Төрийн албаны ерөнхий шалгалт өгөөгүй нийт 14 албан хаагчийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн Б/31 дүгээр тушаалаар төрийн албанаас чөлөөлж, хуульд нийцүүлэн ажилласан. Бусад нийтлэг болон тусгай шаардлага хангаагүй томилсон албан хаагч байхгүй болно.			90
Үүрэг даалгавар ДӨРӨВ: Төрийн улс төрийн, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан тушаалд хууль тогтоомжоор тогтоосон тусгай шаардлагыг хангаагүй томилогдсон албан хаагчийг чөлөөлж, хуульд нийцүүлж ажиллах. /Бүх шатны нутгийн захиргааны байгууллагууд/				
4	Дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2023 оны байдлаар төрийн улс төрийн, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан тушаалд хууль тогтоомжоор тогтоосон тусгай шаардлагыг хангаагүй томилсон албан хаагч байхгүй болно.			90
Үүрэг даалгавар ТАВ: Төрийн жинхэнэ албан тушаалд ерөнхий болон тусгай шалгалт өгөөгүй, тэнцээгүй томилогдсон, Төрийн албаны тухай хууль, уг хуулийг дагаж гарсан дүрэм, журмыг зөрчиж томилогдсон албан хаагчийг чөлөөлж, хуульд нийцүүлж ажиллах. /Бүх шатны нутгийн захиргааны байгууллагууд/				
5	Төрийн албаны ерөнхий шалгалт өгөөгүй нийт 14 албан хаагчийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн Б/31 дүгээр тушаалаар төрийн албанаас чөлөөлж, хуульд нийцүүлэн ажилласан.			90
Үүрэг даалгавар ЗУРГАА: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй, түүнчлэн тухайн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, улсын үйлдвэрийн газрын дүрмээр тогтоосон журмын дагуу томилогдоогүй, ажил үүргийн тодорхойлолтод заасан мэргэжил, мэргэшил, ур чадварын болон бусад шаардлагыг хангаагүй томилогдсон ажилтан, албан хаагчийг чөлөөлж, хуульд нийцүүлж ажиллах. /Бүх шатны нутгийн захиргааны байгууллагууд/				
7	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй, түүнчлэн тухайн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, улсын үйлдвэрийн газрын дүрмээр тогтоосон журмын дагуу томилогдоогүй, ажил үүргийн тодорхойлолтод заасан			90

	мэргэжил, мэргэшил, ур чадварын болон бусад шаардлагыг хангаагүй томилогдсон ажилтан, албан хаагч 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар байхгүй байна.			
Үүрэг даалгавар ДОЛОО: "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг"-ийг Авлигатай тэмцэх газраар хянуулаагүй томилогдсон, хөрөнгө орлогоо мэдүүлэх үүргээ биелүүлээгүй, ашиг сонирхлын зөрчилтэй гэж тогтоосон ч төрийн албанд томилогдсон албан хаагчийг чөлөөлж, хуульд нийцүүлж ажиллах. /Бүх шатны нутгийн захиргааны байгууллагууд/				
8	"Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг"-ийг Авлигатай тэмцэх газраар хянуулаагүй томилогдсон, хөрөнгө орлогоо мэдүүлэх үүргээ биелүүлээгүй, ашиг сонирхлын зөрчилтэй гэж тогтоосон ч төрийн албанд томилогдсон албан хаагч 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар байхгүй болно.			100
Үүрэг даалгавар НАИМ: Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, нийтлэг хэм хэмжээг удаа дараа зөрчсөн нь эрх бүхий этгээдийн шийдвэрээр тогтоогдсон албан хаагчийг чөлөөлж, хуульд нийцүүлж ажиллах. /Бүх шатны нутгийн захиргааны байгууллагууд/				
9	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэмжээнд 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, нийтлэг хэм хэмжээг удаа дараа зөрчсөн нь эрх бүхий этгээдийн шийдвэрээр тогтоогдсон албан хаагч байхгүй болно.			90
Үүрэг даалгавар ЕС: ИРГЭДИЙН ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД: 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулагдах "Барилгын чанар, аюулгүй байдал, стандарт" сэдэвт зөвлөгөөнд байгууллагын удирдлагууд идэвхтэй оролцох. /Дүүргийн Засаг дарга нар, Зарим агентлаг, харьяа газрын дарга нар/				
10	"Барилгын чанар, аюулгүй байдал, стандарт" сэдэвт зөвлөгөөнд 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2 удирдах албан хаагч хамрагдсан.			100
Үүрэг даалгавар АРАВ: Стандартын шаардлага хангахгүй, эрсдэлтэй амралт, хүүхдийн тоглоомын талбайд хяналт шалгалтыг дүүрэг бүрээр зохион байгуулж, стандартыг мөрдүүлэх чиглэлээр эзэмшигч, ашиглагч байгууллагуудад зөвлөмж, мэдэгдэл хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах. /Хотын стандарт хяналтын газар, Дүүргийн Засаг дарга нар/				
10	Дүүргийн нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэнгийн арчлалт хамгаалалтад Засаг даргын Тамгын газрын Тохижилт нийтийн аж ахуйн хэлтсийн мэргэжилтэн, Чингэлтэй дүүргийн "Тохижилт Үйлчилгээ" ХХК-ийн инженертэй хамтран 03 сарын 24-ний өдөр үзлэг шалгалт зохион байгууллаа. Үзлэг шалгалтад нийт 77 бичил цэцэрлэг, тоглоомын талбайг хамруулан цас цэвэрлэгээний ажил, тоглоомуудыг угаах, засварын ажлууд болон өмнөх сард "Тохижилт Үйлчилгээ" ХХК-д өгсөн үүрэг даалгавруудын хэрэгжилтийг хангуулан ажилласан.			70
Үүрэг даалгавар АРВАН НЭГ: Худалдаа, үйлчилгээний газар болон гадна хаяг, хаягийн байгууламжийн стандартыг хангуулах, нийтийн эзэмшлийн гудамж, талбайд зөвшөөрөлгүй байршуулсан, урагдсан, өнгө үзэмжгүй хаяг, зар сурталчилгааны байгууламжуудыг буулгах ажлаа эрчимжүүлж ажиллах. /Захирагчийн ажлын алба, Хотын стандарт хяналтын газар, Дүүргийн Засаг дарга нар/				
11	Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн А/20 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж дүүргийн Засаг даргын А/78 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг орон сууцны 1-6 дугаар хорооны Засаг дарга нарт мэдэгдэх хуудас хүргүүлж, нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд зөвшөөрөлгүй байрлуулсан 45 самбарыг буулгасан. Төрийн болон төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгийн хайс, хашлага дээр нааж байрлуулсан 28 зарлалын хуудсыг бүрэн арилгуулсан. Дүүргийн гэр хорооллын 7-24 дүгээр хорооны нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй самбар байрлуулсан 140 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад мэдэгдэх хуудас хүргүүлж 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн буулгалтын ажлыг хийхээр төлөвлөн ажиллаж байна. Дүүргийн нутаг дэвсгэрт самбарын зөвшөөрөл авахаар 15 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүсэлт гаргасныг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд уламжилсан.			30

Үүрэг даалгавар АРВАН ХОЁР: Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэрийн худалдаа, үйлчилгээний газруудын гадна орчны цэвэрлэгээ, тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хог хаягдлыг ангилан ялгах, түр хадгалах цэгийн стандартыг хангуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах. /Дүүргийн Засаг дарга нар/			
12	<p>Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн “Бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг дүүрэг бүр зохион байгуулах тухай” 2023 оны 01 дүгээр тушаалаар батлагдсан.</p> <p>Тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн Засаг даргын орлогчийн 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 2/686 тоот албан даалгаврыг 1-24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хүнс, худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч нийт 427 иргэн, аж ахуйн нэгжид хүргүүлж, гадна орчны цэвэрлэгээ, тохижилтыг хийлгэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтран ажилгүй 240 иргэдийг түр ажлын байраар ханган 1-24 дүгээр хороо тус 10 хүн хуваарилан нийтийн эзэмшлийн гудамж зам талбай цэвэрлэгээ, хайс хашлага, сандал, хогийн сав, хөшөө дурсгалын цэвэрлэгээ хийж гүйцэтгэлээ.</p> <p>Дүүргийн 7-24 дүгээр хороодын 6 байршилд үргэлжилсэн далан, суваг дагуу түүвэр цэвэрлэгээг өдөр бүр зохион байгуулан ажилласан.</p> <p>Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд: Хаврын мод тарих арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан 2023 оны 02 дугаар улирлаас хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p>		70
Үүрэг даалгавар АРВАН ГУРАВ: 2023 оны 03 дугаар сарын 20-оос эхлэн “Сүхбаатарын талбай” дээр иргэд, олон нийтэд зориулсан аялал жуулчлал, соён гэгээрүүлэх, нийгэм, соёл урлагийн арга хэмжээнүүд зохион байгуулагдах гэж байгаатай холбогдуулан байгууллагууд идэвх, санаачилгатай оролцох. /Бүх шатны нутгийн захиргааны байгууллагууд/			
13	<p>“Сүхбаатарын талбай”- д иргэд, олон нийтэд зориулсан аялал жуулчлал, соён гэгээрүүлэх, нийгэм, соёл-урлагийн арга хэмжээний дараах хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллахаар бэлтгэл ажлыг хангасан Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Хаврын 33 дахь удаагийн “Номын баяр” 2023.05.19-2023.05.21-ний өдрүүдэд ➢ “Автомашингүй өдөр” 05 дугаар сарын 27-ны өдөр ➢ “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр” 06 дугаар сарын 01-ний өдөр <p>Монголчуудын уламжлалт соёл, үндэстэн ястны дээл хувцас, эд хэрэглэл, ардын урлагийн биет болон биет бус өвийг гадаад, дотоодын иргэд, жуулчдад сурталчлан таниулах “Дээлтэй Монгол” арга хэмжээг 07 дугаар сарын 09-ний өдөр тус тус зохион байгуулна.</p>		30
Үүрэг даалгавар АРВАН ДӨРӨВ: Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулагдах “Стратегийн команд штаб”-ын сургуулийн бэлтгэл ажил, зохион байгуулалтаа сайтар хангаж ажиллах. /Дүүргийн Засаг дарга нар/			
14	<p>Монгол Улсын Шадар сайдын 2022 оны Стратегийн Команд штабын сургууль зохион байгуулах тухай 06 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2023 оны Стратегийн команд штабын сургууль зохион байгуулах тухай А/194 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн Онцгой комиссын хуралдааныг зохион байгуулсан.</p> <p>Дүүргийн Онцгой комиссын даргын 02 дугаар тушаалаар сургуулийн удирдагчаар дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга (хурандаа Б.Батбилэг), сургуулийн удирдагчийн орлогчоор Засаг даргын Тамгын газрын дарга (П.Баянбаатар), Цэргийн штабын дарга (хурандаа Н.Энхбат) нарыг томилсон.</p> <p>Дүүргийн Онцгой комиссын 03 дугаар хурлын тэмдэглэл, Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/83 дугаар захирамжийн хүрээнд Онцгой комиссын удирдах бүрэлдэхүүнд Онцгой байдлын Ерөнхий газрын дэд дарга, бригадын генерал Б.Ууганбаяр</p>		90

	<p>“Ослын үеийн удирдлагын тогтолцоо-Хариу арга хэмжээ, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах үеийн гамшгаас хамгаалах албадын удирдлагын гүйцэтгэх үүрэг, харилцан ажиллагаа” сэдэвт сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдөр Нийслэлийн Онцгой байдлын газрын Соёлын төвд зохион байгуулсан. Сургалтад дүүргийн удирдлага, Онцгой комиссын гишүүд, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгж байгууллага, хороодын Засаг дарга нар, дүүргийн Онцгой байдлын хэлтсийн нийт 149 алба хаагчийг бүрэн хамруулан ажиллалаа.</p>			
<p>Үүрэг даалгавар АРВАН ТАВ: “Стратегийн команд штаб”-ын сургуулийн хүрээнд хийгдэх Гамшгаас хамгаалах танхимын болон биет дадлага, сургалт болон бэлэн байдлын үзлэгтэй батлагдсан хуваарийн дагуу байгууллагынхаа ажилтан, албан хаагчдыг бүрэн хамруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах. /Дүүргийн Засаг дарга нар, Хэрэгжүүлэгч агентлаг харьяа газрын удирдлагууд/</p>				
15	<p>“Стратегийн команд штаб”-ын сургуулийн хүрээнд: “</p> <ul style="list-style-type: none"> ➢ Удирдах бүрэлдэхүүнд 3 удаа 200 алба хаагчид; ➢ Гамшгаас хамгаалах алба мэргэжлийн ангийн сургалтыг 1 удаа 21 ажилтанд; ➢ Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын ажилтан, албан хаагчдад 20 удаа 737 ажилтанд; ➢ Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад 5 удаа 1174 сурагчдад; ➢ Нийт 39 удаагийн сургалтаар 1550 ажилтан алба хаагчид Газар хөдлөлтийн үед авах арга хэмжээ” сэдэвт сургалтыг цахимаар болон танхимаар тус тус зохион байгуулсан. <p>Чингэлтэй дүүргийн Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлтэй хамтран 2023 онд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Ерөнхий боловсролын 17 сургуулийн 152 сурагчдад мэдлэг чадвар олгох чадавхжуулах сургалтыг зохион байгууллаа.</p>			90

ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Л.БАЯРМАА

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА

Н. НАРАНЗУЛ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
НЭГТГЭСЭН:

Г.ГООМАРАЛ

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Т.ТҮВШИНЖАРГАЛ